

ГУТГААР БҮЛЭГ. ГАЗАР НУТГИЙН НЭРИЙН СУДАЛГАА

МАНЖ, БОГД ХААНТ МОНГОЛ УЛСЫН ҮЕИЙН ГАЗАР НУТГИЙН ЗУРАГТ ГАЗАРЗҮЙН БИЕТИЙГ ТЭМДЭГЛЭСЭН НЬ

Ж.Нарангарав

Өгүүллийн гол зориго нь МУИС-ийн “Нэр судлалын төв”-ийн зургийн санд буй Манж, Богд хаант Монгол улсын үеийн газар нутгийн зураг болоод дээрх зургийг баримт болгон эмхэтгэсэн “Манж, Богд хаант Монгол улсын үеийн газар нутгийн нэрийн зүйлчилсэн толь” бүтээлийг эх сурвалж болгон газар нутгийн оноосон болоод дэвсгэр нэрийг зурагт хэрхэн буулгасныг харуулахад оршино.

Манжийн үеийг судалсан судлаач Б. Баярсайхан засаг захиргааны нэгжийн бүтцийн талаар тэмдэглэхдээ: “Манжууд нэгэнтээ эрхшээлдээ оруулсан Ар Халхыг 1691 оноос засаг захиргаа нутаг дэвсгэрийн хувьд өөрчлөх нөгөө талаар төрийн байгууллага, төрийн албаны бүтэц зохион байгуулалт, чиг үүргийг шинэчлэн боловсруулах, өөрийн бодлогыг нийгэм, улс төр, эдийн засгийн бүхий л салбар чиглэлээр нэвтрүүлж эхэлсэн байдаг. Үүний нэг илрэл нь засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хуваарийг шинэчлэн өөрчилж, түүнд тохирсон төрийн байгууллага барьж эхэлсэн...”¹ гэжээ.

Манж, Богд хаант Монгол улсын үед үйлдсэн, давхардсан тоогоор нийт 260 орчим хошуу, шавь, харуул, өртөөний зураг манай “Нэр судлалын төв”-д бий бөгөөд эл өгүүлэлд бид Халхын дөрвөн аймгийн давхардсан тоогоор 208 орчим зурагаас хамгийн олон нэр тэмдэглэгдсэн дөрвөн хошууны зургийг сонгон баримт болгов. Тэдгээрийг тухайлбал :

Засагт хан аймгийн Ахай Бэйсийн хошуу 1915

Сайн ноён хан аймгийн Сайн ноён ханы хошуу 1916

Сэцэн хан аймгийн Ачит Бэйсийн хошуу 1913

Түшээт хан аймгийн Дайчин бэйсийн хошуу 1914 онуудад тус тус үйлдсэн бөгөөд зургуудад газар нутгийн нэр болоод газарзүйн биетийг тэмдэглэсэн нь харилцан адилгүй байна.

Манж, Богд хаант Монгол улсын үеийн газрын зургийн уламжлалын талаар судлаачдын өгүүлсэн нь бий. Үүнд: Б. Гончигдорж “Монголын газрын зурагт уул нуруу

1 Б. Баярсайхан “Манж дайчин улсын үе дэх Монголын эрх зүйн бодлого, соёлын нөлөө”, 2006., *Mongolica*, vol.19(40), 16-17

Ж.Нарангарав

МУИС-ийн Газарзүй геологийн факультет
ng.narangarav@yahoo.com

Фүтаки Хироши, Камимүра Акира, Э.Равдан, Л.Чулуунбаатар

Монгол орны газрын зураг болон газар нутгийн нэрийн судалгааны асуудлууд
МУИС пресс хэвлэлийн газар, Улаанбаатар, 2012, ISBN 978-99962-72-59-2

хажуу бэлээс нь харсан байдлаар дүрслэн улмаар Монгол үндэсний уран зургийн арга барилаар зурсан байна. Ой модтой уулыг, дээгүүр нь мод зурах буюу хад асга бүхий нүцгэн уулыг хад зурах монгол зургийн маягаар дүрслэж, улаан-ягаан, улаан-шараар будсан байдаг. Уулыг түүний үргэлжилсэн буюу хэсэг нэг бүлгээрээ орших шинж чанары нь илэрхийлэн салаа салбарын хамт үзүүлэхийг оролдсон байх боловч зарим зурагт бүх уулыг нэг адил зурж таних тэмдгийн маягаар хэрэглэсэн байдал ч үзэгдэнэ. Уулыг дүрслэхдээ:

1. Нутгийн төвөөс эргэн тойрон харлаа гэж санаад уулын оройг төвөөс тал, тал тийш нь унагаж хэвтүүлсэн байдлаар зурсан байна.
2. Бүх уулын оройг гол мөрний саваас хоёр тийш нь унагаж хэвтээ байдлаар зурсан байна. Уулыг нэг талаас нь харж байна гэж санаад оройг нь дээш харуулан зурсан байна. Ийм зураг дээр нутгийн ар, өвөр этгээдийн аль талаас харж зурсан болохыг бичгээр тэмдэглэсэн байдаг.

Зураг дээр уулын дүрсийн хажууд уулын нэрийг бичиж, түүний өндрийг бичгээр тэмдэглэхийн хамт уулын өндрийг хэмжихдээ одон орны зурхайд од, гаригийн өндрийг хэмжин бодож олохтой адилаар тригонометрийн аргыг хэрэглэж далайн төвшнөөс биш уулын бэлээс хэмжсэн байна.

Ер нь эртний монголчуудын хийсэн газрын зургийг ажиглахад байгалийг дүрслэсэн монгол үндэсний уран зураг санаанд орно. Монгол уран зурагт байгалийг дүрслэхдээ зурагч хүний харааны өндрийн төвшинг өндөрт авч (зурагч хүн өндөр уулын орой дээр) буюу агаарт байгаа мэтээр зурдаг байсан нь орчин үед барилга байгуулалтын бүхэл бүтэн нэгдмэл хэсгийг дүрслэхдээ хүний харааны өндрийг газрын гадаргууг 100 метрийн өндөрт авч дүрсэлдэгтэй ойролцоо болж байна.

Газар орныг ингэж дүрслэх явдал эртний Энэтхэг, Хятад, Япон, Солонгос, Орос улсад нилээд дэлгэрчээ. Энэ бол газрын гадаргуу ба түүн дээр байгаа юмсыг их хэмжээгээр харуулах боломжийг өгч байгаа хэрэг юм.

Монгол зурагт гол, мөрөн, нуур зэргийг дэвсгэр зургийн план маягаар дүрслэсэн байна. Усыг дан хөх өнгөөр буюу эсхүл Монгол уран зурагт зурдагтай адилаар долгио, боргио гарган өнгийн дагнаас хэрэглэн будсан байна. Гол мөрний урсах чиг, булан тохой, салаа салбарыг нэлээд ойролцоо байршилтай зуржээ.

Зураг дээр сүм хийд зэрэг суурин газрыг нэг сүмийн дүрсээр, хушуу тамгын газрыг нэг гэрийн дүрсээр тэмдэглэж нэрийг хажууд нь бичсэн байна. Зарим зурагт төв суурин газрыг тэр байгаа хэвээр нь зурж үзүүлсэн явдал ч тохиолдож байна. Жишээлбэл: Хиагт орчмын газрын нэг зурагт Хиагтын сууринг жинхэнэ харагдах байдлаар нь зурсан байв. ... Эдгээр зурагт ихэнх газар, уул нуруудыг ногоон өнгөөр будсан байх бөгөөд элс, сайр бүхий газрыг шар, улаан шар өнгөөр будаж тийм сайр, тийм говь гэж нэрийг бичсэн байдаг. ... Мөн оны орчим хийсэн Хөвсгөл аймгийн зурагт сум, өртөө, машины зам, төмөр утасны шугам, хоршоо, хамтрал намын үүр, эвлэлийн үүр, сургууль зэргийг таних тэмдгээр нарийн ялган зурсан байна.”² хэмээжээ.

МУИС-ийн ГГС-ийн багш Д. Эрдэнэцэцэг өөрийн бүтээлдээ монгол зургийн талаар дээрхтэй ижил зүйлийг өгүүлсэн байх бөгөөд уг үеийн зургийг “нарийн хэмжээсгүй, нэлээд бүдүүвч төдий, ихэнхидээ зөвхөн хошууны нутаг, засаг захиргааны эзэмшил харьяаллыг тодорхойлох зорилгын үүднээс зохиож байжээ.”³ гэжээ.

Харин проф. Ц. Шагдарсүрэн бүтээлдээ “Монголчуудын хийж ирсэн газрын зураг нь зөвхөн хил хязгаарханыг татсан цулгай зураг байгаагүй нь мэдээж бөгөөд хаана хаана ямар уул ус, гол горхи, булаг шанд, сүм хийд, хүй гацаа, зам харгуй байдаг, уул гэхэд хэр өндөр, модтой эсэх, нуур гэхэд хэр гүн, шорвог эсэхийг, гол мөрөн гэхэд урсгалын чиг зэргийг нарийн заадаг уламжлалтай байжээ. Энэ бүхэнийг нийт улс даяар нэгэн маягаар мөрддөг байсны баримт одоо Улсын түүхийн төв архивт хадгалагдаж буй Бадаргуулт төрийн 16

² Б. Гончигдорж “Монголчуудын газарзүйн зургийн түүхийн зарим асуудал”

³ Д. Эрдэнэцэцэг “Зурагзүйн хангамж ба их, дээд сургуульд зориулагдсан сери зургийн зохиолтын аргагүйн асуудал”, УБ., 2000

дугаар он болон Олонаа өргөгдсөний 3 дугаар оны баримтаас мэдэж болно.”⁴ гэжээ.

Түүнчлэн Л. Алтанзаяа, Ц. Шагдарсүрэн нарын бүтээлд “уул овоонд толгойг хойш хандуулан зурагтун”⁵ гэснийг тэмдэглэсэн байна.

Дээрх эрдэмтэд болоод баримтад дан ганц газар нутгийг болоод газарзүйн биетийг зурагт буулгахыг өгүүлээд, нэрийг хэрхэн тэмдэглэх талыг нь орхисон байна.

Газар нутгийн нэр судлалыг газарзүй, түүх, хэл шинжлэл зэрэг шинжлэх ухааны зааг дээр үүссэн гэж үздэг. Нэр нь аливаа амьтай, амьгүй юмс үзэгдэл, биетийг нэрлэн заах үндсэн үүрэгтэй бөгөөд газар нутгийн нэрийн хувьд оноосон болоод дэвсгэр нэрээс бүрдэл болно. Дэвсгэр нэр нь оноосон нэрийн үндсийг бүрдүүлж, утгыг тайлах ба танин мэдэхүйн шууд холбоотой. (Э. Равдан, 2008, 11-р тал)

Манай орны хувьд энэ чиглэлийн судалгаа хөгжиж буй салбар бөгөөд анх гадны монголч эрдэмтэд өөрсдийн бүтээлдээ тодорхой хэмжээгээр оруулж байсан ба тэдгээрээс анхны дэвсгэр нэр, нэрийг газрын зурагт хэрхэн буулгах талаар анх Оросын судлаач В. А. Казакевич хөндсөн байна. Тэрээр “...Нэргүй газрын зураг хэлгүй хүн лугаа ижил ... энэ улсын газрын зургийг зөвхөн гадаадын иргэд бүтээдэг байжээ. Тэд нь эхлээд манжийн эзлэн түрэмгийлэгчдийн алба хашигч элч төлөөлөгчид, дараа нь Төв Азид тагнуул, туршуул хийж байсан капиталсит оросын судлаачид байлаа. Тэр хүмүүсийн аль аль нь улс орных нь хэлэнд огт анхаараагүй эсвэл анхаарсан ч хэлний баримтыг нь маш бага ашигласан байна. Түүнээс үүдэн Төв штабын 40 бээрийн масштабтай газрын зураг болон түүнийг бүтээх үндэс болсон бүх маршрутын зурагт ер бусын олон алдаа гарчээ”⁶ гэжээ.

Тэрбээр нийт нутгийн зургийг зүүнээс баруун тийш чанарын хувьд муудсан гэж үзсэн ба энэ байдал нь тухайн үеийн улс төр, нийгмийн тогтолцоотой холбоотой хэмээн тйалбарлажээ. Өөрөөр хэлбэл “Манж, хятадын нөлөө нутгийн нөлөө зүүн хэсэгт илүүтэй байгаад, баруун зүгрүү суларсан” гэж үзжээ (Дэлхийд тархсан Монгол газар нутгийн нэр I, УБ., 2005, 34 тал).

Казакевичаас хойш монгол газар нутгийн дэвсгэр нэрийн судалгаанд гадаад, дотоодын цөөнгүй эрдэмтэн хандсан байна. Энд М. Н. Мельхеев, Г.И. Донидзе, В.Э. Очир-Гаряев, Т. А. Бертагаев зэрэг эрдэмтдийн бүтээл дэвсгэр нэрийн судалгаатай холбоотой байна. (Э. Равдан “Монгол орны газар нутгийн нэрзүй” бүтээлээс үзнэ үү). Манай орны эрдэмтдийн хувьд харьцангуй сүүлд судлаж эхэлсэн ба энд Х. Пэрлээ, Ш. Шагдар, Ч. Догсүрэн, О. Сүхбаатар зэрэг эрдэмтдийн бүтээл байна. Анхны 1:1500 000 масштаб бүхий газрын зургийг 1959 онд Д. Бадамжав үйлдсэнээр үндэсний зурагзүйчдийн томоохон бүтээл гэж үздэг. Мөн 1940 оноос хойш 35000 орчим нэрийг шинээр газрын зурагт байршуулсан зэрэг нь чухалд тооцогддог.

Газрын зураг үйлдэх, түүнд газар нутгийн нэрийг тусгах үйлийг салган ойлгож, аль нэгийг нь орхигдуулж боломгүй юм.

Бид энэхүү ажилд дөрвөн аймгийн сонгон авсан дөрвөн хошууны нийт 1029 оноосон нэр, түүний 48 дэвсгэр нэрийг авч үзэв. Дэвсгэр нэрийг ерөнхийд нь:

- Ороним буюу уулын тухайт нэрийн зүйл
- Гидроним буюу усны тухайт нэрийн зүйл
- Газрын тэг хийгээд хотгор гадаргуутай нэрийн зүйл
- Фитоним буюу ургамалын тухайт нэрийн зүйл хэмээн авч үзэх болно.

Сонгон авсан газрын зурагт дүрслэлийн хувьд дэвсгэр нэр хэрхэн тэмдэглэгдсэнийг авч үзвэл:

⁴ Ц. Шагдарсүрэн “Монголчуудын утга соёлын товчоон”, 2003., УБ, 19-р тал

⁵ Л. Алтанзаяа “XVII-XX зууны эхэн үеийн Халх Монголын хошууны нутгийн зургийн тухайд”, 2002., УБ, Түүхийн сэтгүүл, Том III Fasc.10, 70-78

Ц. Шагдарсүрэн “Монголчуудын утга соёлын товчоон”, 2003., УБ, 22 тал

⁶ “Дэлхийд тархсан Монгол газар нутгийн нэр”, УБ., 2005, 34-тал “В. А. Казакевич “Орчин үеийн Монгол газар нутгийн нэр судлал” (Современная монгольская топонимика (Изд-во АН ССР, Ленинград, 1934))”

	Үйлдсэн он	Нийт нэр	Дэвсгэр нэр	Тайлбар/ Онцлог
Засагт Хан аймаг Ахай Бэйсийн хошуу	1915	127	-	-Уулын тухайт нэрийн зүйл болоод сүм, байшин, овоог перспектив, нэрийг зураг дээр, -Усны тухайт нэрийн зүйл болох нуурыг ареалын аргаар, гол, булгийг шулуун шугамын аргаар, нэрийг 2 талд нь, -Хиллэх хошууг, хаанаас хаа хүртлэх хил хязгаарыг хамт заасан байна. -Гол онцлог нь уулын тухайт нэрийн зүйлийг өмнөд, хойд 2 талаас нь харуулахыг хичээсэн.
Сайн Ноён Хан аймаг Сайн Ноён Ханы хошуу	1916	250		Торлолтой, 4-н зүг бичсэн -Уулын тухайт нэрийн зүйл, ургамалын тухайт нэрийн зүйл болох мод, мөн сүм, байшин, овоог перспектив, нэрийг зураг дээр, -Усны тухайт нэрийн зүйл болох нуур, худаг, шанд, мөн ургамалын тухайт нэрийн зүйл дэрсийг ареалын арга, тэмдгэн дүрслэлээр, гол, булгийг шулуун шугамын аргаар, нэрийг 2 талд нь, -Хилийн овоог геометрийн дүрслэлээр, буюу тал дугуйгаар дүрслээд, нэрийг нутгийн төврүү хандуулан бичжээ. -Газар нутгийн нэрийг бичихдээ нэрийн оноосон болоод дэвсгэр нэрийн араас баг, сум гэсэн байх нь олонтаа. Тухайлбал, <i>Их булаг үүний баг, Орхон гол үүний сум гэх мэт.</i>
Сэцэн Хан аймаг Ачит Бэйсийн хошуу	1913	327	-	-Торлолтой, 4 зүгийг заасан -Уулын тухайт нэрийн зүйл, сүм, байшин, гэр зэргийг перспектив, нэрийг зургийн доор, -Усны тухайт нэрийн зүйл болох нуурыг ареалын арга, тэмдгэн дүрслэлээр, гол, булагийг, хилийн шугамыг шулуун шугамын аргаар, -Хилийн овоог газарзүйн биетээр харуулан нэрийг 1-64 хүртэл дугаарлан, төв тийш хандуулан бичжээ. -нэг газраас илүү өндөр уулын өндрийг (газар, хувь, алд) ¹ , голын урсах чиг болоод урт, өргөнийг (газар, хувь, алд), нуурын өргөнийг (газар, хувь, алд) заасан байна. -Хилийн овооны гадна талаар, хил залгаа аймаг хошуудыг, хиллэх овооны тооны хамтаар зааж өгчээ.
Түшээт Хан аймаг Дайчин Бэйсийн хошуу	1914	323		-Торлолтой, 4-н зүг бичсэн, -Уулын тухайт нэрийг перспектив аргаар зурж, 1 хувиас илүү өндрийг заасан, -Усны тухайт нэрийн зүйл болох худаг ус мөн сүм, дуган, жасыг геометрийн дүрсэн тэмдгийн аргаар зурж нэрийг хойд зүгт хандуулан бичсэн байна. -Хилийн шугамыг зураасаар буюу шулуун шугамын аргаар зурж, хилийн овоог геометрийн дүрслэлээр буюу тэгш өнцөгтөөр дүрслэн, нэрийг төв тийш хандуулж бичсэн байна. Усны тухайт зүйлин нэрийг бичихдээ дэвсгэр нэрийг тусгайлан ялгалгүй бүгдийг ус хэмээн бичжээ. Мөн бүх нэрийг тэмдэглэсэн газарзүйн биетийн доор бичсэн.

¹ Нэг газар - 576м, нэг хувь – 57,6м, нэг алд – 1,6 м

Дээрх дөрвөн зурагт тэмдэглэгдсэн дэвсгэр нэрсийг аймаг, хошуудаар харьцуулан харвал дараах байдалтай байна.

	Дэвсгэр нэр	Засагт хан аймаг Ахай Бэйсийн хошуу	Сайн ноён хан аймаг Сайн Ноён Ханы хошуу	Сэцэн хан аймаг Ачит Бэйсийн хошуу	Түшээт хан аймаг Дайчин Бэйсийн хошуу	Нийт
1	Аариг			1		1
2	Албаны газар			2	1	3
3	Бөөрөг	1				1
4	Булаг		12	12	4	28
5	Булан	1				1
6	Бунхан			1		1
7	Бууц		1			1
8	Бүрд		8	2	2	12
9	Гол	7	34	5		46
10	Горхи			7		7
11	Гэр			2		2
12	Даваа			1		1
13	Далан	1				1
14	Дуган	1				1
15	Дэл	1		1		2
16	жас		1		3	4
17	Зам			2	1	3
18	Их газар			1		1
19	Нуруу		19			19
20	Нуур	4	6	52		62
21	Овгор	3				3
22	Овоо	3			54	57
23	Овоо (хилийн)			64	96	64
24	Өртөө				8	8
25	Рашаан		1	1		2
26	Салаа	1				1
27	Сүм		2	3	2	7
28	Сүүж		2			2
29	Тал		2			2
30	Тал газар				3	3
31	Талбай			1		1
32	Толгод				2	2
33	Толгой	5		1	7	13
34	Тээл	1	3			4
35	Ус	1	23	1	88	320
36	Уул	2	11	39	30	82
37	Ухаа	3				3
38	Хад		4		1	5
39	Хоолой			1		1
40	Хөндий	1				1
41	Худаг		23			23
42	Хүрэм		3			3
43	Хүрээ			1		1
44	Цав				2	2
45	Цахир	1				1
46	Чулуу	4	2	1	4	11
47	Шанд		3			3
48	Шил			4		4

Хошуудын газар нутгийн нэрийг ажиглахад дэвсгэр нэр эсвэл оноосон нэрийг орхигдуулсан байх нь цөөнгүй тохиолдолд таарч байна. Тухайлбал, *Гүн жаргалан, Говь Түшээт Хан аймаг, Орхонбаянулаан үүний сум, Зүүн сөдтэй, Бүрд Сайн Ноён Хан аймаг, Борзагал, Рашаан Сэцэн Хан аймаг, Ямаат, Ёлт, Эргэцэг* Засагт Хан аймаг гэх мэт болно. Дэвсгэр нэрийг бичилгүй орхигдуулсан нь тухайн нэрийг тэр бүр оноон ойлгоход зарим талаар төвөгтэй.

Харин давтамжаар нь харвал:

Ус 320	Чулуу 11	Шанд 3	Бунхан 1
Уул 82	Горхи 7	Дэл 2	Бууц 1
Овоо(хил) 64	Сүм 7	Рашаан 2	Даваа 1
Овоо 57	Хад 5	Сүүж 2	Далан 1
Нуур 62	Тээл 4	Тал 2	Дуган 1
Гол 46	Шил 4	Толгод 2	Талбай 1
Булаг 28	Зам 3	Цав 2	Хоолой 1
Худаг 23	Овгор 3	Аариг 1	Хөндий 1
Нуруу 19	Тал газар 3	Бөөр 1	Хүрээ 1
Толгой 13	Ухаа 3	Бөөрөг 1	Цахир 1
Бүрд 12	Хүрэм 3	Булан 1	

(Ус 320, уул 82, овоо(хил) 64, овоо 57, нуур 62, гол 46, булаг 28, худаг 23, нуруу 19, толгой 13, бүрд 12, чулуу 11, горхи 7, сүм 7, хад 5, тээл 4, шил 4, зам 3, овгор 3, тал газар 3, ухаа 3, хүрэм 3, шанд 3, дэл 2, рашаан 2, сүүж 2, тал 2, толгод 2, цав 2, аариг 1, бөөр 1, бөөрөг 1, булан 1, бунхан 1, бууц 1, даваа 1, далан 1, дуган 1, талбай 1, хоолой 1, хөндий 1, хүрээ 1, цахир 1) байх ба үүнийг дээрх дөрвөн хошууны хүрээнд давтамжаар нь харуулбал:

Засагт хан аймаг Ахай Бэйсийн хошуу		Сайн ноён хан аймаг Сайн Ноён Ханы хошуу		Сэцэн хан аймаг Ачит Бэйсийн хошуу		Түшээт хан аймаг Дайчин Бэйсийн хошуу	
Дэвсгэр нэр	нийт	Дэвсгэр нэр	Нийт	Дэвсгэр нэр	Нийт	Дэвсгэр нэр	Нийт
Гол	7	Гол	34	Овоо (хилийн)	62	Овоо (хилийн)	96
Толгой	5	Ус	23	Нуур	52	Ус	88
Нуур	4	Худаг	23	Уул	39	Овоо	54
Чулуу	4	Нуруу	19	Булаг	12	Уул	30
Овгор	3	Булаг	12	Горхи	7	Толгой	7
Овоо	3	Бүрд	8	Гол	5	Булаг	4
Ухаа	3	Нуур	6	Шил	4	Чулуу	4
		Хад	4	Сүм	3	жасаа	3
		Тээл	3			Тал газар	3
		Шанд	3				

Эндээс харахад усны тухайт нэрийн зүйлийг буюу гол, ус, булаг зэрэг дэвсгэр нэрийг илүүтэйгээр тэмдэглэн заасан байх агаад үүний дараа уулын тухайт нэрийн зүйл байна. Энэхүү байдал нь нэгт, газар дэлхийгээ шүтэн, мал аж ахуй эрхлэн амьдардагтай, хоёрт, тухайн цаг үеийн нийгмийн хөгжил, улс төрийн байдалтай шууд холбоотой гэхээр байна.

Хүрээлэн буй орчин болоод нийгмийн түвшинтэй холбоотой гэдэг нь бусад суурин соёлтой, хөгжингүй орны газар нутгийн нэртэй харьцуулан харахад л илхэн харагдах зүйл юм. Ялангуяа дэвсгэр нэрийн байдал хөгжингүй орны хувьд уул, нуруу, гол, мөрөн, далай, зам, гудамж гэх зэргээр хязгаарлагдах бол манай оронд нилээд баялаг. Тухайлбал, уулын тухайт дэвсгэр нэрэнд ам, ар, ангал, залаа, зоо, зураа, зээг...шил, шовгор гэх зэрэг 200 орчим дэвсгэр нэрийг хамаатуулан үзэж болохоор аж. (Э. Равдан, 2008, 31-р тал)

- Манж, Богд хаант Монгол улсын үеийн газрын зураг нь баруунаас зүүн тийш болох тусам чанарын хувьд муу гэсэн нь илэхнээ харагдаж байна.
- Аймаг, хошууны хувьд газрын зурагт нэр тэмдэглэх нь ялгаатай бөгөөд нэрийн тэмдэглээний тал дээр тодорхой дүрэм журам байгаагүй, дэвсгэр нэрийг эсвэл оноосон нэрийг орхигдуулсан нь цөөнгүй харагдаж байна.

- Усны тухайт нэрийн зүйл, гол, булаг, нуур хийгээд уулын тухайт дэвсгэр нэр, тэр дундаа уул, толгойн нэрийг илүүтэй тэмдэглэн заасан байна.


Засагт хан аймаг Ахай бэйсийн хошуу 1915



Сайн ноён ханы хошуу МУ-ын 16 он



Сэцэн хан аймгийн Ачит бэйсийн хошуу 1913



Түшээт хан аймгийн Дайчин бэйсийн хошуу 1914

